



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/511

Мандалговь

Г Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай Г

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Адаацаг сумын Нийтийн ахуй үйлчилгээний барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Батцэнд	("Оргил төсөл" ХХК-ийн захирал)
	Б.Бат-Орших	("Алтан бат өрлөг" ХХК-ийн санхүү хариуцсан захирал)
	Ж.Батхөлөг	(Адаацаг сумын Засаг дарга)
	П.Алтанчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

488010610

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

Гурав. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/448 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ